



**НИЙСЛЭЛИЙН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 4/27

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн хэрэгслийг шалгах  
хуудасны загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/303 дугаар захирамжаар батлагдсан Нийтийн Тээврийн үйлчилгээний газрын “Дүрэм”-ийн 2.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Тушаах нь:

1. Тээвэрлэлтийн ажил үйлчилгээг гүйцэтгэх автотээврийн хэрэгслийн ашиглалтын онцлогт нийцүүлэн боловсруулсан нийтийн тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг шалгах хуудсыг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн тээврийн үйлчилгээний шалгах хуудсыг баталсан загварын дагуу хэвлүүлэх, тээвэрлэлтийн ажил үйлчилгээнд хэрэглэх, мөрдүүлэх ажлыг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулан ажиллахыг нийтийн тээврийн үйлчилгээ-эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад үүрэг болгосугай.

3. Автотээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, эрх бүхий албан тушаалтан тэмдэглэл хийсэн эсэхэд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /З.Цэвээндорж/-т, Техникийн үзлэг оношилгооны төв /Ц.Нанжид/-д тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Орлогч дарга /Ц.Мягмар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Х.БУЛГАА



Нийтийн тээврийн үйлчилгээний газрын  
даргын 2019 оны 05 дугаар сарын 08 ний  
едрийн 127 дугаар тушаалын хавсралт



**Нийтийн тээврийн хэрэгслийг шалгах хуудас**

20.. оны ... сар ... өдөр .....цаг ... минут.

Тээврийн хэрэгслийн загвар, марк ....., Улсын дугаар ....., Гарааш дугаар .....,

Жолоочийн овог, нэр .....

Нийтийн тээврийн үйлчлэх чиглэлийн дугаар .....

Тэмдэглэгээ хангасан /O/, хангаагүй /X/

Нийтлэг шаардлага	Хурд хэмжүүр, дуут дохио бүрэн ажиллагаатай эсэх	
	Хийн системийн ажиллагаа хэвийн эсэх	
	Дугуйн хийн даралт, хээний гүн стандартад заасан хэмжээнээс багагүй	
	Шил алчуур, цан үлээгүүр хэвийн ажиллагаатай эсэх	
	Хамгаалах бүс байгаа эсэх	
	Автобусны гадна дотор талын болон оврын гэрэлтүүлэг стандартын шаардлага хангасан эсэх	
	Маршрут заах, таних тэмдгийн гэрэлтүүлэг, арын цацруулгагч бүрэн эсэх	
	Заал болон хаалганы гэрэлтүүлэг бүрэн эсэх	
	Эмийн сан, гал унтраагуур, ослын зогсолтын тэмдэг байгаа эсэх	
	Салхины шил цуурсан зөрчилгүй эсэх	
	Гараашийн дугаар, чиглэлийн хаяг стандартын дагуу байршуулсан эсэх	
	Хяналтын камер болон ледийн ажиллагаа хэвийн эсэх	
Хөдөлгүүр, хүч дамжуулах анги	Хөдөлгүүр, хурдны хайрцаг, ерөнхий дамжуулагаас тос, хөргөх системээс шингэн гоожсон эсэх	
	Дискэн холбоо /авцуулах/ салахгүй буюу хий эргэхгүй байх	
	Сэнсний оосрын элэгдэл, тохиргоо, гэмтэлтэй эсэх	
Тоормосны систем	Яндан болон дуу намсгуур хэвийн эсэх	
	Дөрөөний сул ба бүрэн явалт	
	Тоормосны шингэн болон хий дамжуулах хоолой, гуурсны битүүмж хэвийн эсэх болон хийн системийн тундас авсан байдал.	
Жолооны механизм	Зогсоолын тоормос хэвийн эсэх	
	Жолооны хүрдний сул явалт	
	Жолооны хүрдийг эргүүлэх хүч	
Явах анги	Жолооны удирдлагын дамжуулга, татуурга, гар нугасан холбоос, эргэх нударганы сул явалт	
	Нум /хийн нум/ пүршний байдал	
	Амортизаторын хэвийн байдал	
Цахилгаан хэрэгсэл	Дугуй, булны бэхэлгээний байдал	
	Аккумуляторын /клем/ шон, болон бусад цахилгаан утасны холболт, бүрээс нь хэвийн эсэх	
Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний талаар	Нийтийн тээврийн үйлчилгээний батлагдсан цагийн хуваарь, замналын зургалалтай байх	
	Дотор цэвэрлэгээ хийгдсэн эсэх	
	Гадна цэвэрлэгээ хийгдсэн эсэх	
	Зорчигчийн бариул, суудлын бэхэлгээ, бүрээс хэвийн эсэх	
	Улсын дугаарын харагдах байдал хэвийн эсэх	
Шалгагч, Жолоочид тавих шаардлага	Smart цахим төхөөрөмж болон зогсоол зарлан, мэдээлэх хэрэгсэл ажиллаж байгаа эсэх	
	ХАБЭА -н зааварчилгаа авсан байх	
	Жолоочийн хувийн бэлтгэл хангагдсан эсэх жолооны үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, замын хуудас, мэргэшсэн жолоочийн үнэмлэх, ажлын хувцас, нэрийн хуудас бүрэн эсэх	
	Жолоочийн биеийн байдал, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх	
Цахилгаан болон Байгалийн шахсан /CNG/ хийн тэжээлт тээврийн хэрэгсэл	Байгалийн шахсан хий болон /CNG/, цахилгаан тэжээлт автобусны жолооч нь тусгайлан ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байна.	
	Шахсан хийн тээврийн хэрэгслийн тэжээлийн системийн битүүмж болон даралтад савны аюулгүй байдал хэвийн эсэх	
	Цахилгаан автобусны техникийн байдлыг шалгаж жолоочид техникийн болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсөн байна.	

Шугамд гарахын өмнө тээврийн хэрэгсэлд техникийн ерөнхий үзлэг хийж үйлчилгээнд гарах ба шугамаас буухдаа тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг шалгах механикчаар заавал шалгуулна.

Техникийн хяналт хийж зөвшөөрсөн

Шалгах механик .....

Жолооч .....



## Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- МУ-ын замын хөдөлгөөний дүрмийн дагуу хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж хөдөлгөөнд оролцох.
- Жолооч та ажилд гарахын өмнө автобусныхаа тоормозны систем, гэрэл дохио, хаалга, толь, дугуйн хийн даралтыг шалгасны дараа шалгах механикт шалгуулж шугам замд гарах.
- Автобусныхаа техникийн ажиллагааг шалгах үедээ гадны хүн оролцуулахгүй байх, байрнаас нь хөдөлгөхдөө орчны аюулгүй байдлыг сайн харж нягталсаны дараа хөдөлгөөнд оролцох, ухрах үйлдэлд хийхдээ арын саад үгүйг нягтлаад дуут дохио өгч ухрах.
- Согтууруулах ундаа хэрэглэсэн, биеийн байдал, эрүүл мэнд муудсан, хэт ядарсан үед тээврийн хэрэгсэлийг жолоодохгүй байх.
- Шугаманд ажиллахдаа замын хөдөлгөөний дүрмийг чанд биелүүлж, урдаа яваа тээврийн хэрэгсэлийг зогсоход түүнийг мөргөхгүй, хажуу дахь тээврийн хэрэгсэлийг шүргэхгүй байх хэмжээний зайг барьж явах.
- Автобусны зогсоолд зогсохдоо автобусыг бүрэн зогсоосны дараа хаалгаа нээж, зорчигчдыг бүрэн сууж байраа эзэлсэний дараа хаалгаа хаан хөдөлгөөнийг эхлэх, замын хөдөлгөөнд оролцохдоо гар утсаар ярихыг хориглох.
- Төмөр замын гарам нэвтрэх замын хөдөлгөөний дүрмийг чанд сахих.
- Автобусны хөдөлгөөн дунд жолоочтой ярих, анхаарлыг нь сарниулах, жолоочид нөлөөлөх байдал үүсгэж явах, хөдөлгөөн дунд цэвэрлэгээ хийхийг хориглох.